

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-11
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	12-27

1.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.04.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	12-14
2..Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	14-15
3.Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 14 гишүүн 2024.05.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	15-18
4.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	18-24
5.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	24
6.Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	24-25
7.”Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан/	25-27

***Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Нийгмийн бодлогын байнгын хорооны 05 дугаар сарын 21-ний өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 58.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 58 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Б.Баярсайхан, Б.Бейсен, С.Ганбаатар, Б.Саранчимэг, Ц.Туваан.

Нэг.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.04.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх Д.Баасандамба, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх Р.Батрагчаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх Р.Батрагчаа хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх Д.Баасандамба, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх Р.Батрагчаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, мөн газрын референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамиуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Д.Сарэнгэрэл: Улсын Их Хурлын гишүүн П.Анужингийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “эсхүл” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 6
Бүгд: 11
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Сарангэрэл: Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Сарангэрэл: Төслийн 2 дугаар зүйлийн “эсхүл” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Д.Сарангэрэл: Улсын Их Хурлын гишүүн П.Анужингийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн хуулийн дагаж мөрдөх хугацааг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 14 гишүүн 2024.05.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Ундрал, мөн яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч Ю.Отгонбилэг, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Ахмад настны хөгжлийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн Ө.Гэрэлт-Од, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Д.Баясгалан, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч С.Жаргалсайхан, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Тусламж, үйлчилгээний багц, зохицуулалтын хэлтсийн дарга Б.Баярболд, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга С.Тунгалагтамир, Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны референт Д.Наран-Отгон, “Юзисан партнерс” хуулийн фирмийн зөвлөх хуульч Н.Энхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нямбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын тавьсан асуултад ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, “Юзисан партнерс” хуулийн фирмийн зөвлөх хуульч Н.Энхбат нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсний дагуу санал хураалт явуулав.

Д.Сарангэрэл: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 7.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.8.Энэ хуулийн 7.6-д заасан “Ахмадын өргөө”, бусад төв нь төрийн болон орон нутгийн өмчит барилга байгууламжид байрлан үйл ажиллагаагаа явуулж байгаа бол барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засварын зардлыг гэрээний үндсэн дээр орон нутгийн төсвөөс хэсэгчлэн, эсхүл бүрэн санхүүжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл төслүүд /Засгийн газар 2024.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Н.Гэрэлт-Од, мөн газрын Салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийн судалгаа, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Г.Түвшинбаяр, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Энхтуяа, мөн газрын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга Л.Зэндмаа, Эмийн бүртгэлийн хэлтсийн дарга Т.Мөнхтуул, Эм хангамжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Оюун-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Д.Баясгалан, Гаалийн ерөнхий газрын Хорио цээрийн хэлтсийн Эм, биобэлдмэлийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч М.Пүрэвсүрэн, “Эрүүл мэнд реформ” Төрийн бус байгууллагын гишүүн М.Халиунаа, Монголын эм зүйн байгууллагын нэгдсэн “Эм” холбооны гүйцэтгэх захирал И.Балжинням, Монголын эмнэлгийн инженерчлэлийн нийгэмлэгийн тэргүүн М.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсний дагуу санал хураалт явуулав.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар:

Д.Сарангэрэл: 1.Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Б.Жаргалмаа, М.Оюунчимэг, Д.Сарангэрэл, Ж.Чинбүрэн /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан,

Төслийн Хоёрдугаар бүлгийн гарчгийн “олгох,” гэсний дараа “сунгах, түдгэлзүүлэх, сэргээх,” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “нөлөөт эм” гэсний дараа “, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж нэмж, мөн зүйлийн 6.1.2 дахь заалтын “биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл гэсэн төрлөөр” гэснийг “эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж өөрчилж, 6.1.1 дэх заалтын “эмнэлгийн хэрэгсэл,” гэснийг, 6.1.2 дахь заалтын “/уламжлалт эм/” гэснийг, мөн зүйлийн 6.2 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “хамт тухайн” гэснийг “хуулийн этгээд” гэж, мөн хэсгийн “нийлүүлэх тусгай зөвшөөрөл олгоно” гэснийг “нийлүүлж болно” гэж, 7.2.1, 7.2.2 дахь заалтын “сан бүхий энэ хуулийн 6.1.3-т заасан худалдах” гэснийг “сангийн” гэж, мөн заалтын “дүүргийн эмийн сангүй” гэснийг “сангийн хүрэлцээгүй” гэж, 7.2 дахь хэсгийн, 7.5.1, 7.5.2, 7.5.3, 7.5.4 дэх заалтын “олгох, сунгахад” гэснийг “олгоход” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 7.5 дахь хэсгийн “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3.1-д,” гэснийг, 7.13 дахь хэсгийн “хууль эрх зүйн хүрээнд” гэснийг тус тус хасаж, 7.1 дэх хэсгийн “бүтээгдэхүүнээ” гэсний дараа “түүхий эдээ” гэж, 7.11 дэх хэсгийн “саналаар” гэсний дараа “хуралдааны шийдвэр” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 7.16 дахь хэсэг нэмэх:

“7.16.Энэ хуулийн 7.5.1, 7.5.3, 7.5.4, 19.1, 29.2.4-т заасан зохистой дадлын стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “энэ хуулийн 7.5-д заасан баримт бичгийг бүрдүүлж,” гэснийг хасаж, мөн хэсгийн “энэ хуулийн 8-11 дүгээр зүйлд заасан үүрэг, шаардлагыг биелүүлсэн байна” гэснийг “Эрүүл мэндийн тухай хуулийн 19.17-д заасныг үндэслэнэ” гэж өөрчилж, мөн зүйлийн 12.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 41 дүгээр зүйлийн 41.1, 41.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“41.1.Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн хүсэлт, баримт бичиг, түүнд хийсэн

шинжээчийн дүгнэлт, лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн уг бүтээгдэхүүнийг бүртгэнэ.

41.6.Энэ хуулийн 41.1-д заасны дагуу бүртгэгдсэн эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний жагсаалтыг цахим хуудсанд байршуулж, эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хяналт тавина.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	4
Бүгд:	11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 41 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 41.12 дахь хэсэг нэмэх:

“41.12.Энэ хуулийн 41.6-д заасны дагуу бүртгэгдсэн эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг иргэн, хуулийн этгээд борлуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	4
Бүгд:	11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.2.3, 46.9, 46.10 дахь хэсгийн “тусламж, төсөл, хөтөлбөрөөр” гэснийг “тусламжаар” гэж, 46.10.1 дэх заалтын “шаардлага” гэснийг “стандарт” гэж, 46.10.6 дахь заалтын “эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүнийг” гэснийг “эмийг” гэж тус тус өөрчилж, 46.11 дэх хэсгийн “Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг хасаж, мөн хэсгийн “46.10.6” гэсний дараа “46.10.7” гэж нэмж, 46.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“46.1.Тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авахад эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, хандивын эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авахад эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тус тус урьдчилан мэдэгдэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	5
Бүгд:	11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 47 дугаар зүйлийн 47.1.1 дэх заалтын “болон орон нутгийн”, “иргэнд үзүүлэх” гэснийг, 47.1.4 дэх заалтыг тус тус хасаж, мөн зүйлийн 47.1.1 дэх заалтын “шаардлагатай” гэснийг “түгээмэл хэрэглэгддэг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	3
Бүгд:	11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн тавьсан асуултад ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Хамт өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Д.Сарангэрэл: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 13.17 дахь заалтын “нөлөөт эм,” гэсний дараа “, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж нэмж, 13.18 дахь заалтын “биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл гэсэн төрлөөр” гэснийг “эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж өөрчилж, мөн заалтын 13.17 дахь заалтын “эмнэлгийн хэрэгсэл,” гэснийг, 13.17, 13.19 дэх заалтын “гэсэн төрлөөр” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “12.1 дэх заалтын” гэсний дараах ““Эмийн” гэснийг “Эм, эмнэлгийн хэрэгслийн” гэж, мөн заалтын” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “13.6” гэсний дараа “, 13.7” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн П.Анужин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Н.Гэрэлт-Од, мөн газрын Салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийн судалгаа, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Г.Түвшинбаяр, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Энхтуяа, мөн газрын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга Л.Зэндмаа, Эмийн бүртгэлийн хэлтсийн дарга Т.Мөнхтуул, Эм хангамжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Оюун-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Д.Баясгалан, Гаалийн ерөнхий газрын Хорио цээрийн хэлтсийн Эм, биобэлдмэлийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч М.Пүрэвсүрэн, “Эрүүл мэнд реформ” Төрийн бус байгууллагын гишүүн М.Халиунаа, Монголын эм зүйн байгууллагын нэгдсэн “Эм” холбооны гүйцэтгэх захирал И.Балжинням, Монголын эмнэлгийн инженерчлэлийн нийгэмлэгийн тэргүүн М.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Д.Сарангэрэл: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 2

Бүгд: 10

80.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа. Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Н.Гэрэлт-Од, мөн газрын Салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийн судалгаа, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Г.Түвшинбаяр, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Энхтуяа, мөн газрын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга Л.Зэндмаа, Эмийн бүртгэлийн хэлтсийн дарга Т.Мөнхтуул, Эм хангамжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Оюун-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Д.Баясгалан, Гаалийн ерөнхий газрын Хорио цээрийн хэлтсийн Эм, биобэлдмэлийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч М.Пүрэвсүрэн, “Эрүүл мэнд реформ” Төрийн бус байгууллагын гишүүн М.Халиунаа, Монголын эм зүйн байгууллагын нэгдсэн “Эм” холбооны гүйцэтгэх захирал И.Балжинням, Монголын эмнэлгийн инженерчлэлийн нийгэмлэгийн тэргүүн М.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Д.Сарангэрэл: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	2
Бүгд:	10

80.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Долоо. "Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай"
Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Н.Гэрэлт-Од, мөн газрын Салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийн судалгаа, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Г.Түвшинбаяр, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Энхтуяа, мөн газрын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга Л.Зэндмаа, Эмийн бүртгэлийн хэлтсийн дарга Т.Мөнхтуул, Эм хангамжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Оюун-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Д.Баясгалан, Гаалийн ерөнхий газрын Хорио цээрийн хэлтсийн Эм, биобэлдмэлийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч М.Пүрэвсүрэн, "Эрүүл мэнд реформ" Төрийн бус байгууллагын гишүүн М.Халиунаа, Монголын эм зүйн байгууллагын нэгдсэн "Эм" холбооны гүйцэтгэх захирал И.Балжинням, Монголын эмнэлгийн инженерчлэлийн нийгэмлэгийн тэргүүн М.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Тогтоолын төслийг хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, С.Чинзориг нарын тавьсан асуултад хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Тогтоолын төслийг Эрүүл мэндийн сайдын саналаар хэлэлцэхийг хойшлуулав.

Байнгын хорооны хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 04 минут үргэлжилж, 19 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр 17 цаг 02 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

П.АНУЖИН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Их засаг”
танхим 15 цаг 58 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Д.Сарангэрэл: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Нийгмийн бодлогын байнгын хорооны өнөөдрийн 5 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаан эхэлж байна. Ирц 58.8 хувьтай бүрдсэн учраас хурал эхэлж байна аа. Ирц заавал танилцуулах ёстой юм уу тэ? Анужсин гишүүн ирсэн, Баярсайхан гишүүн байхгүй байна, Батлут гишүүн ирсэн. Бейсен гишүүн байхгүй байна, Булгантуяа байхгүй байна, С.Ганбаатар байхгүй байна, Жаргалмаа гишүүн ирсэн, Мөнх-Оргил гишүүн байхгүй байна. Оюунчимэг гишүүн, Сарангэрэл гишүүн исэн, Саранчимэг гишүүн байхгүй байна, Одонтуяа гишүүн ирсэн, Туваан гишүүн байхгүй байна, Чинбүрэн гишүүн ирсэн, Чинзориг гишүүн ирсэн, Идэрбат гишүүн ирсэн.

Ирц 58.8 хувьтай байгаа учраас өнөөдрийн хуралдаан эхэлж байна аа.

Хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя.

Өнөөдрийн байнгын хороогоор хэлэлцэх асуудал

1.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Монгол Улсын Ерөнхийлөгч 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн Эцсийн хэлэлцүүлэг,

2.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамиуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Монгол Улсын Ерөнхийлөгч 2024 оны 5 дугаар сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг,

3.Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд нарын 14 гишүүн 2024 оны 5 сарын 2-ны өдөр өргөн мэдүүлсэн эцсийн хэлэлцүүлэг,

4.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Засгийн газар 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг,

5.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,

Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,

Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг хийгдэнэ ээ.

Хэлэлцэх асуудлын дараалал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

1.Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Ирчихсэн байна уу? Ажлын хэсэг Баасандамба Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх Бригадын

генерал, Рагчаагийн Батрагчаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх нэг хүн байгаа юм байна. Танилцууллаа.

Эцсийн хэлэлцүүлгийн материалыг та бүхэнд тараасан байгаа.

Эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Сандаг-Очир гишүүнээр тасалъя.

Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Энд манай энэ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас бас хүн байхгүй юм аа. Энэ Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд бас цаашидаа бас энэ хуулийн төсөлд орсонгүй. Энэ зөвхөн амь насаа албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан улсуудад буцалтгүй тусламж орон байраар хангах асуудал яригдаж байна. Амь насаа алдахаас алдаагүй ч гэсэн алба үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэндээрээ хохирчихсон, гар хөлгүй болчихсон, нүд ам нь сохорчихсон хөдөлмөрийн чадвараа алдсан ийм улсууд зөндөө байгаа байхгүй юу. Тэгээд одоо ингээд л маш олон жил маш олон байгууллагуудаар явж байгаа. Ерөнхийлөгчийн нэр дээр хүсэлт өгсөн л гэнэ, ЦЕГ л гэнэ, Ерөнхий сайд гээд. Жишээ нь Багануур дүүргийн 1 дүгээр хорооны иргэн Энхжаргал гэж хүн жишээ нь маш олон жил гомдол тээгээд л явж байгаа юм. Түүнээс болоод хараагүй сохор болчихсон гээд, хөдөлмөрийн чадвараа алдсан тэгээд түүнээс болж амьдрал ахуй нь эрс дордсон. Ингээд төр бас харж үзэх ёстой гээд л.

Ингээд ноднин 2 жилийн өмнө харин одоогийн ерөнхийлөгч Хүрэлсүх дарга Багануур дүүргийн цагдаагийн албанд ажиллаж байгаад бас энэ ХанУулд нэг айхтар гэмт хэрэг гараад албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан. Тэгээд түүний гэр бүл үр хүүхдүүдэд бас орон сууцын асуудал яриад маш олон жил явж байгаад харин Хүрэлсүх ерөнхийлөгч өгнө гэж хэлээд

өгсөн. Баттулга Ерөнхийлөгчийн үед өгнө гээд өгч чадаагүй. Би юу хэлэх гээд байна вэ гэхээр энэ эрүүл мэндээрээ хохирчихсон амь насаа яг алдаагүй ч гэсэн эрүүл мэндээрээ хохирчихсон, хөдөлмөрийн чадвараа алдчихсан энэ улсуудад манай онцгой, цагдаа, шүүхийн шийдвэр, хилийн цэргийн анги, цэргийн ангиуд энэн дээр ер нь ямар дэмжлэг тусалцаа байдаг юм бэ? Цаашидаа ер нь бас энэ тал дээр нэгэнт л албан үүргээ гүйцэтгэж яваад ингээд эрүүл мэндээрээ хохирчихсон юм чинь одоогийн хуульд нь ямар заалт байдаг юм. Өөр цаашидаа энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал байна уу үгүй юу? Байж болох уу, үгүй юу? Энэ дээр нэг Ерөнхийлөгчийн зөвлөх юм уу, хуулийн зөвлөхүүдээс нэг тайлбар өгөөч.

Д.Сарангэрэл: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Батрагчаа зөвлөх 2 дугаар микрофоныг өгье.

Р.Батрагчаа: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 12 дугаар зүйл дээр хөдөлмөрийн чадвар алдсан тэтгэмжийн хэмжээний талаар бол тодорхой заасан байгаад байгаа. Яг Сандаг-Очир гишүүний саяын ярьсантай холбоотойгоор бас нэг тодорхой хэмжээнд хууль бас нэг тодорхой хэмжээний цоорхой байна аа гэдэг үүднээс хуульд заасан чиг үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлагад өртөх гэмт хэргийг таслан зохих гэсэн бас нэмэлт өөрчлөлтийг Ерөнхийлөгчөөс өргөн барьсан хуулийн төсөл дээр бол оруулж өгсөн. Яагаад вэ гэвэл гэмт халдлагыг таслан зогсоох буюу нэг ёсондоо гэмт халдлагад өртсөн тохиолдолд ямар нэгэн тэтгэмжийн асуудал бас учир дутагдалтай явж байсан. Тэрийг нь бол нөхөж оруулах хэлбэрээр явсан байгаад байгаа. Ерөнхийлөгчөөс өргөн барьсан тохиолдолд бол амь насаа алдсан

тохиолдлыг яг тодорхой нөгөө эрх зүйн зохицуулалтуудыг нь тодорхой, ойлгомжтой, бас тодорхой хэмжээгээр төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг нь дээрдүүлэх зорилгоор хуулийн төслийн гол концепт зорилго нь бол хийгдсэн. Гэхдээ бол энэ цаашид бол яг энэ зохицуулалтын дагуу бас тодорхой хэмжээгээр Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 10.1.1-д заасных нь дагуу тодорхой хэмжээний бас эрх зүйн байдал нэмэгдэж өгч явж байгаа.

Гэхдээ бол яг таны хэлдгээр нөгөө хөдөлмөрийн чадвар алдсан тэтгэмжийн хэмжээний талаар бол тодорхой өөрчлөлт ороогүй.

Д.Сарангэрэл: Ер нь бол Сандаг-Очир гишүүний энэ асуултад бас жоохон бодолцох ёстой юм байна. Одоо бид нарын яг хэлэлцэж байгаа бол амь насаа алдсан тохиолдолд гэж байгаа юм. Таны саяын хариулт болохоор зэрэг гэнэтийн халдлагад өртсөн үед гэж байна. Тэгвэл бас осол бол яах вэ гээд янз бүрийн тохиолдлууд байгаа. Тэрэн дээр ер нь энэ чинь хүн өөрийнхөө нөгөө чадвар, олон чадваруудаа алддаг шүү дээ тийм ээ. Амь насаа алдаагүй ч гэсэн тэр тохиолдолд яах юм бэ гэдэг ийм зүйлүүдийг яриад байгаа юм. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас төлөөлөл алга байна.

Бас Байнгын хороо энэ асуудлыг би анхаарах ёстой гэж бодож байна. Сандаг-Очир гишүүн тодруулах уу? Баярлалаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Чуулганы нэгдсэн хуралдаанд эцсийн хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг. Санал хураах уу? Санал хураахгүй ээ. Хэн унших

вэ? Жаргалмаа гишүүн унших уу? Жаргалмаа гишүүн уншъя.

16.07 цагт

Хоёр дахь асуудал. *Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024 оны 5 дугаар сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд урамшуулал олгох тухай хуулийн төсөлд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.*

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх Батрагчаа зөвлөх, Сархадын Зулпхар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд, Болдын Ундрал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн Халамжийн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга. Манай ажлын хэсгийнхэн маань бүрэлдэхүүнээрээ ирсэн байна аа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны тухай дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Санал байхгүй байна.

2-т төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан нэг санал бэлтгэсэн байна. Энэ саналыг та бүхэндээ танилцуулъя.

1.Төслийн 2 дугаар зүйлийн “эсхүл” гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Анужсин.

Санал хураалт.

Идэрээ гишүүн санал гаргая.

Ц.Идэрбат: Би сая дэмжиж санал өгсөн боловч эсрэг гарсан байна. Санал хураалтыг хүчингүй болгож дахиж явуулж өгнө үү?

Д.Сарангэрэл: Идэрбат гишүүний саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Сонсохгүй байгаа юм шиг байна.

Томьёоллыг уншиж танилцуулсан байгаа.

Санал хураалт.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Санал хураалт.

60 хувиар санал хураалт дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? байхгүй байна.

Төсвийн зарчимтай уялдуулан хууль хэрэгжүүлэх он сарыг 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжүүлэхтэй холбогдсон нэг санал байна.

Санал хураалт.

Төслийн 3 дугаар зүйлийн хуулийн дагаж мөрдөх хугацааг 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Анужин.

Санал хураалт.

Манайхан анхааралтай байж байгаад хэдүүлээ гялс гялалзуулчихъя.

60 хувиар дэмжигдлээ. Баярлалаа.

Энэ дээр нэгний гэдгийг юу эм үгийн и биччихээрэй.

Анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Энхболд нарын 14 гишүүнээс 2024 оны 5 дугаар сарын 2-ны өдөр өргөн мэдүүлсэн Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийнэ ээ.

Танилцуулгыг Сарангэрэл хийнэ.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хийчхээд танилцуулах юм байна тэ? Тийм.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Энхболд нарын 14 гишүүнээс 2024 оны 5 дугаар сарын 2-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн.

Хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д зааснаар хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 7.8 дахь хэсгийг өөрчлөн найруулах зарчмын зөрүүтэй нэг санал бэлтгэлээ.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Ажлын хэсгээс боловсруулан оруулж

байгаа зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Болдын Ундрал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Амарсайханы Хишигбаяр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Сандагийн Тунгалагтамир ХЭҮК-ын Тамгын газрын Судалгаа дүн шинжилгээний хэлтсийн дарга, Өөр болчихсон юм уу? Би буруу бичлээ гэж бодлоо шүү дээ. Дамбаагийн Наран-Отгон Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны референт, Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Өлзийхутагийн Гэрэлт-Од Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахмад настны хөгжлийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн, Дүгэрсүрэнгийн Баясгалан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн. Манай Баясаа байхгүй байна уу? Түрүүн харагдаж байсан даа. Сэмбэдоржийн Жаргалсайхан ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын шинжээч, Бүдрагчаагийн Баярболд ЭМД-ын ерөнхий газрын Тусламж үйлчилгээний багц зохицуулалтын хэлтсийн дарга. Манай Баярболд дарга байна тэ? Нэргүйн Энхбат Юзисан Партнерс хуулийн фирмийн ахлах зөвлөх, хуульч байна.

Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Алга байна. Уучлаарай Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Гүйцээн боловсруулах ганц л юм байгаа юм. Энэ дээр өргөө болон бусад төв нь төрийн болон орон нутгийн өмчит байгууламжид байрлан гэж байгаа байхгүй юу. Энэ дээр ер нь орон нутагт

хувийн хэвшилтэй ч гэсэн хамтраад ажиллачих ийм бас бололцоонууд гардаг шүү дээ. Танай энэ байрыг ашиглачихъя. Энэ урсгал зардлыг нь энд ингээд төлөөд явчихъя гээд ингээд тэгэхээр тэр боломжийг нь нэг мөр ер нь нээгээд өгчихвөл яасан юм. Яагаад ганцхан төр болон орон нутгийн өмч гэж ингэж заасан юм бэ гэж тодруулъя.

Д.Сарангэрэл: Идэрбат гишүүний асуултад хариулна. Ажлын хэсгийн ахлагчийн хувьд товчхон хариулт өгөөд тэгээд манай ажлын хэсгийнхэн дэлгэрүүлээд хариулаад өгөөрэй.

Ер нь бол Идэрбат гишүүн ээ бид нар ахмадын чиглэлээр төрөөс баримталж байгаа бодлого, Ахмад настны тухай хууль ингээд юмнууд байгаад байгаа юм. Энэ удаагийн хуулийн төслөөр ер нь нэлээн тийм нарийвчилж зааж өгсөн, ерөнхий заалтууд байгаад байхаар эзэнгүй орхигдоод ахмадын чиглэлийн энэ төрийн бодлого огт хэрэгжихгүй байгаа учраас нэлээн детальчилж өгсөн. Хамгийн түрүүнд төр өөр дээрээ жоохон функц авъя ачаалал авъя. Төрийн байгууллагууд дээр байрлаж байгаа ахмадын байгууллагуудын тэр урсгал зардлыг төрийн байгууллага төсвийн хүрээндээ ингээд хариуцаад явах юм бол эхний ээлжид ямар ч байсан ахмадынхаа байгууллагуудыг дэмжээд явах ийм бололцоог нь нээх юм. Үүнээс үлгэрлээд бас хувийн байгууллагууд маань бас тодорхой жишиг дагаад бас яваад байх юм болов уу гэсэн ийм анхны санаачилгыг л тусгаж өгье гэдэг ийм санаагаар хийсэн юм байгаа юм.

Тэгээд манай ажлын хэсгийн хариулна даа. Отгонбилиг байна уу? Манай Энхбат. Манай Энхбат, хуульч хариулъя. Нэг номерын микрофон өгье.

Н.Энхбат: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Бид 7.8-д Сарангэрэл гишүүн сая яг тодорхой хэллээ. Бид нар төрийн байгууллагуудыг энэ ачааллыг өөрсдийнх дээрээ авч ингэж хийсэн эхний

ээлжид зохистой юм аа гээд бас судалгаан дээр бас энэ талаар гарсан. Тэгээд энэнийхээ дагуу боловсруулагдсан байгаа.

Д.Сарангэрэл: Тэгээд гишүүн бас хуулиар нөгөө хувийн хэвилийнхнийг ахмадын байгууллага танай байгууллага дээр ажиллах юм урсгал зардал юмнуудыг нь хуулиар өгөх жоохон боломжгүй байгаа учраас энэ удаа хувийн хэвилийн асуудлыг орхиод төрийн байгууллагатай холбоотой ийм чиглэлийн заалтуудыг оруулсан байгаа. Гишүүн тодруулах уу? Идэрбат гишүүн тодруулна.

Ц.Идэрбат: Би бол яах вэ энэ хууль чинь 16, 17 оны хууль шиг санаж байна. Одоо ингээд 7 жилийн дараа өөрчлөгдөж байгаа. Тэгээд яг амьдрал дээр миний хэлээд байгаа нөхцөл байдал үүсдэг юм даа. Гол нь хувийн хэвилийн нэг жоохон байшинг нь ашиглаад ахмадууддаа ашиглуулаад урсгал зардлыг нь төр хариуцаад явчих харамсалтай нь бас тэр нь шийдэгдэж өгөхгүй байдаг байсан. Тэгээд би гол нь энийг нь бүүр нээгээд өгчихвөл ахмадын байгууллагын үйл ажиллагааг явуулах бололцоо юмнуудыг нь гаргахад хамрагдах хүрээний хувьд ч гэсэн би арай ахиц гарах болов уу гэж ингэж л бодож байгаа юм. Тэгэхгүй бол наадах чинь төрийнхөн төрийг дотроо аваад л явдаг шүү дээ. Угаасаа л аваад явдаг шүү дээ. Нэг ахмадын байгууллагаас мөнгө нэхээд байгаа юм байдаггүй шүү. Байдаг ч цөөхөн байдаг байх.

Харин энэ хуулийн үндсэн агуулгадаа нийцүүлээд жоохон ахиц гаргая гэж байгаа бол энэ дээр төр болон орон нутгийн өмч гэхгүйгээр хувийн гээд нэг жоохон заагаад өгчихвөл хувийн хэвилийн нэг том.

Д.Сарангэрэл: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төлөөлөл гишүүний асуултад хариулъя. Хишигбаяр хариулчих. 3 номерын микрофоныг өгье.

А.Хишигбаяр: Идэрбат гишүүний асуултад хариулъя.

Бодлого төлөвлөлтийн газрын дарга Хишигбаяр. Ерөнхийдөө энэ ахмадын тухай хуульд бол бид нар бас илүү хувийн байгууллагууд дээрээ энэ 7.8-ын заалт бүүр яг санхүүжүүлнэ гээд оруулчихсан байгаа. Тэгэхээр одоо заавал ч үгүй санхүүжүүлнэ гэдэг ийм хатуу заалт байгаа учраас яг энэ дээр хувийн байгууллагуудыг санхүүжүүлнэ гэж хэлэх юм өөрөө хувийн байгууллагууд маань бас ачаалал очно гэдэг энэ агуулгаараа бид нар бас оруулаагүй. Нөгөө талаар энэ хууль дээр бид нар ахмадын санг бас хувийн байгууллагууд өөрсдөө бас сан байгуулахаар бид нар компанийн тухай хуульд бас оруулаад өгчихсөн байгаа.

Тэгэхээр энэ сангаасаа бид нар ахмадынхаа байгууллагыг байршуулах ахмадуудаа зарцуулах энэ тэр нь энэ сангийн хүрээнд бол нээлттэй байхаар оруулж өгч хуульчилсан байгаа.

Д.Сарангэрэл: Асуулт асууж хариулт авч дууслаа.

Саналаа хураая.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д заасны дагуу ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрөөтэй нэг саналаар санал хураалт явуулна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 7.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.8.Энэ хуулийн 7.6-д заасан “Ахмадын өргөө”, бусад төв нь төрийн болон орон нутгийн өмчит барилга байгууламжид байрлан үйл ажиллагаагаа явуулж байгаа бол барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засварын зардлыг гэрээний үндсэн дээр орон нутгийн төсвөөс хэсэгчлэн, эсхүл бүрэн санхүүжүүлж болно.” Байж байгаарай.

Төрийн байгууллага юм чинь тэгэх үү?
Тэгье зөв зөв сайд аа.

Бид нар ахмадаа дэмжье гэж л байгаа бол тийм. Тэгээд энэ дээр зүгээр уншихад нөгөө юу ахмадын өргөө болон төв нь ахмадын өргөө болон одоохон. Ахмадын өргөө болон бусад төв нь төрийн болон гэгчихсэн байх юм. Болох уу тэгж тэгэх үү? Тэгэхгүй бол ингээд нэг дор. Нэг болонгоо дарлаа шүү.

Санал хураалт, Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. Ингээд л болоо.

Санал 63.6 хувиар дэмжигдлээ.

Танилцуулгыг Улсын Их Хурлын чуулганд Сарангэрэл ажлын хэсгийн дарга танилцуулна.

16.22 цагт

Дөрөв дэх асуудал. Ажлын хэсэгт баярлалаа.

Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийе.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Ажлын хэсэг орж иртэл би танилцуулга хийгээд орхиё.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж,

эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Ажлын хэсэг 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу явуулж, нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган эцсийн хувилбарын төслийг бэлтгэн хэлэлцүүлээ.

Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үеэр хуралдаан даргалагчаас ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулахгүйгээр.

Төслийн 5 дугаар зүйл. Тус Байнгын хорооны дэмжээгүй 2 санал, хамт өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг гүйцээн боловсруулах чиглэл өгч Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасныг баримтлан төслийн 6, 7, 12, 41, 46, 47 дугаар зүйлийн зарим хэсэг, заалт болон хамт өргөн мэдүүлсэн нь Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар 10 зарчмын зөрүүтэй саналын саналын томьёолол бэлтгэн санал хураалт явуулахад ажлын хэсгийн гишүүдийн олонх дэмжлээ.

Ажлын хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42-т заасныг баримтлан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээ хэмжээний тухай Улсын Их

Хурлын тогтоолын төслийг боловсруулан анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр та бүхэнд танилцуулж байна аа.

Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэн та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ажлын хэсгийг та бүхэндээ танилцуулъя аа.

Дагвадоржийн Очирбат ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга алга байна. Пүрэвийн Оюунцэцэг ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Намдагийн Гэрэлт-Од ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Дүгэрсүрэнгийн Баясгалан ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн, Ганхуягийн Түвшинбаяр ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын салбарын хууль эрх зүйн шинэчлэлийн судалгаа төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн, Шаравнямбуугийн Энхтуяа Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ламжавын Зэндмаа Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын дарга, Лиценз зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга, Даваасүрэнгийн Оюун-Эрдэнэ Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эм, хангамжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Тогтохын Мөнхтуул Эм, эмнэлгийн хэрэгслийн Хяналт зохицуулалтын газрын Эмийн бүртгэлийн

хэлтсийн дарга, Рэнцэнгийн Энхсүрэн Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын албан даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Максимын Пүрэвсүрэн ГЕГ-ын Хорио цээрийн хэлтсийн Эм, био бэлдмэлийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч, Машибаатарын Халиунаа Эрүүл мэнд реформ ТББ-ын гишүүн, Иваны Балжинням Монголын эм зүйн байгууллагын нэгдсэн эмийн холбооны гүйцэтгэх захирал, Мятавын Бат-Эрдэнэ Монголын эмнэлгийн инженерчдийн нийгэмлэгийн тэргүүн.

Манай энэ Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн ажлын хэсэг бол их том бүрэлдэхүүн байгаа.

Манай ажлын хэсэг ийм том бүрэлдэхүүн ч гэсэн маш идэвхтэй ажилдаа хариуцлагатай хандаж байгаа. Саяын ажлын хэсгийн гишүүдийн танилцуулгаас харагдаж байна аа.

Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Эцсийн хэлэлцүүлэг. Алга байна. Асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д заасны дагуу Улсын Их Хурлын даргаас гүйцээн боловсруулах чиглэл өгч ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна.

Нийт 10 санал байгаа.

Төслийн Хоёрдугаар бүлгийн гарчгийн “олгох,” гэсний дараа “сунгах, түдгэлзүүлэх, сэргээх,” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “нөлөөт эм” гэсний дараа “, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж нэмж, мөн зүйлийн 6.1.2 дахь заалтын “биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл гэсэн төрлөөр” гэснийг “эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны

хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж өөрчилж, 6.1.1 дэх заалтын “эмнэлгийн хэрэгсэл,” гэснийг, 6.1.2 дахь заалтын “/уламжлалт эм/” гэснийг, мөн зүйлийн 6.2 дахь хэсгийг тус тус хасах.

Санал хураалт.

54.5 хувийн саналаар
дэмжигдлээ.

2.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “хамт тухайн” гэснийг “хуулийн этгээд” гэж, мөн хэсгийн “нийлүүлэх тусгай зөвшөөрөл олгоно” гэснийг “нийлүүлж болно” гэж, 7.2.1, 7.2.2 дахь заалтын “сан бүхий энэ хуулийн 6.1.3-т заасан худалдах” гэснийг “сангийн” гэж, мөн заалтын “дүүргийн эмийн сангүй” гэснийг “сангийн хүрэлцээгүй” гэж, 7.2 дахь хэсгийн, 7.5.1, 7.5.2, 7.5.3, 7.5.4 дэх заалтын “олгох, сунгахад” гэснийг “олгоход” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 7.5 дахь хэсгийн “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3.1-д,” гэснийг, 7.13 дахь хэсгийн “хууль эрх зүйн хүрээнд” гэснийг тус тус хасаж, 7.1 дэх хэсгийн “бүтээгдэхүүнээ” гэсний дараа “түүхий эдээ” гэж, 7.11 дэх хэсгийн “саналаар” гэсний дараа “хуралдааны шийдвэр” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 7.16 дахь хэсэг нэмэх:

“7.16.Энэ хуулийн 7.5.1, 7.5.3, 7.5.4, 19.1, 29.2.4-т заасан зохистой дадлын стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Ажлын хэсгийг би түрүүн уншаагүй байна. Анужин, Жаргалмаа, Оюунчимэг, Сарангэрэл, Чинбүрэн. Цаашид ажлын хэсэг гэх.

Санал хураалт.

3.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “энэ хуулийн 7.5-д заасан баримт бичгийг бүрдүүлж,” гэснийг хасаж, мөн хэсгийн “энэ хуулийн 8-11 дүгээр зүйлд заасан үүрэг, шаардлагыг биелүүлсэн байна” гэснийг “Эрүүл

мэндийн тухай хуулийн 19.17-д заасныг үндэслэнэ” гэж өөрчилж, мөн зүйлийн 12.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

63.6 хувийн саналаар санал
дэмжигдлээ.

4.Төслийн 41 дүгээр зүйлийн 41.1, 41.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“41.1.Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн хүсэлт, баримт бичиг, түүнд хийсэн шинжээчийн дүгнэлт, лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн уг бүтээгдэхүүнийг бүртгэнэ.

41.6.Энэ хуулийн 41.1-д заасны дагуу бүртгэгдсэн эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний жсагсаалтыг цахим хуудсанд байриуулж, эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хяналт тавина.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

63.6 хувийн саналаар санал
дэмжигдлээ.

5.Төслийн 41 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 41.12 дахь хэсэг нэмэх:

“41.12.Энэ хуулийн 41.6-д заасны дагуу бүртгэгдсэн эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг иргэн, хуулийн этгээд борлуулж болно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

63.6 хувийн саналаар санал
дэмжигдлээ.

6.Төслийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.2.3, 46.9, 46.10 дахь хэсгийн “тусламж, төсөл, хөтөлбөрөөр” гэснийг “тусламжаар” гэж, 46.10.1 дэх заалтын “шаардлага” гэснийг “стандарт” гэж, 46.10.6 дахь заалтын “эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүнийг” гэснийг “эмийг” гэж тус тус өөрчилж, 46.11 дэх хэсгийн “Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг хасаж, мөн хэсгийн “46.10.6” гэсний дараа “46.10.7” гэж нэмж, 46.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“46.1.Тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авахад эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, хандивын эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авахад эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тус тус урьдчилан мэдэгдэнэ гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 47 дугаар зүйлийн 47.1.1 дэх заалтын “болон орон нутгийн”, “иргэнд үзүүлэх” гэснийг, 47.1.4 дэх заалтыг тус тус хасаж, мөн зүйлийн 47.1.1 дэх заалтын “шаардлагатай” гэснийг “түгээмэл хэрэглэгддэг” гэж, 47.7 дахь хэсгийн “бөөний болон жижиглэнгийн үнийн нэмэгдэх хувь хэмжээний” гэснийг “нэмэгдэх хувь, мөнгөн дүнгийн” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Чинзориг гишүүн. Микрофон өгье.

С.Чинзориг: Энэ 7 дугаар зарчмын зөрүүтэй санал дээр тэр бөөний болон жижиглэнгийн үнийн нэмэгдэх хувь хэмжээ гэсэн байсныг нэмэгдэх хувь, мөнгөн дүн гэж өөрчилж байгаа юм байна. Гэхдээ яах вэ Мөнгө хувь хэмжээ тавихаар өндөр үнэтэй юм бол бас хувиараа өндөр өсөлт авна гэж бодоод мөнгөн дэмжлэг гээд мөнгөн дүнг тавьж

байгаа юм шиг байна. Энийг нь бол заавал ингэж тавихгүй хуучнаар нь үлдээчихвэл яадаг юм бэ? Би бол тэр мөн нэмэгдэх өндөр үнэтэй нэмэгдэх бол тэр хувь хэмжээг нь бага тогтоогоод л явчихдаг юм байгаа биз.

Хоёрдугаарт энийг хэрвээ ингэж нэмэгдэх хувь, мөнгөн дүн гээд нэг биччихлээр хувь нэмэгдэх хувийг нь ч л тавина. Мөнгөн дүнг нь ч тавих болчихоод байгаа юм аа. Эсвэл одоо нэмэгдэх хувь эсвэл мөнгөн дүн гэж тавьдаг юм уу? Нэг найруулга.

Хоёрдугаарт хэрвээ энэ би буруу ойлговол Оюунцэцэг та нар хэлээрэй энэ нэмэгдэх хувь, мөнгөн дүн гээд биччихлээр энийг чинь дагалдаад цаана нь 3, 4 заалтад өөрчлөлт орох гээд байгаа юм. Тэрийг нь эсвэл ав эсвэл одоо тэр мөн ерөөсөө энэ заалтаа хасчих. 47.8, 8.2.4, 9.4.6, 10.8.10 эд нар дээр ингээд дандаа тэр мөнгөн дүн гэдэг юм чинь заалт орох гээд байгаа юм. Эсвэл тэр заалтаа нэм, эсвэл энийг ер нь энэ нэмэгдүүлэх гэдгийгээ авчих Сарангэрэл. Би бол бараг л ч авчих нь зөв л гэж бодсон шүү дээ.

Д.Сарангэрэл: Чинзориг сайдаа сая ажлын хэсэг хуралдаад олонхоороо дэмжсэн. Энд бол бас тийм Чинбүрэн гишүүний санал ч байгаа. Их үндэслэлтэй саналууд байгаад байгаа юм. Энэ бол зөвхөн одоо нөгөө компанийн гэдэг юм уу, гаальтай гэдэг юм уу тэрэнтэй холбоотой асуудал биш. Зөвхөн эмийн сангийн түвшиний асуудал. Одоо тэр гааль дээр үйл ажиллагааны зардал өөрийнхөө ашиг юмнуудаа бодоод ингээд хувь нэмээд ингээд яваад байгаа. Тэгээд эмийн сан дээр хүрч ирээд дахиад 20 хувь нэмэгдэж байгаа.

Тухайлбал 5 мянган төгрөгийн үнэтэй 10 мянган төгрөгийн үнэтэй өөрөөр хэлбэл үйлдвэрлэгчийн нэг төрлийн эм гэхэд эмийн сангууд аль болох өндөр үнэтэй эмийг нь зарах сонирхолтой. Яагаад гэвэл нөгөө эмийн санд орж ирэх ашиг нь өндөр. Энэ заалт хийснээр бид

нар иргэнд ээлтэй нөгөө үнийн одоо асуудал яригдаад байгаа шүү дээ. Тэрэн дээр л гол зүйл болох юм байна л даа. Шууд ерөөсөө 20 хувиар жижиглэнгийн үнэ нэмэх тухай асуудал биш. Харин ЭМД-ын үндэсний зөвлөлтэйгөө одоо хэлэлцээрт ороод мөнгөөр нэмэх 20 хувь гэхих юм бол дахиад өндөр үнэ нэмэгдэх болчихоод байгаа. Иргэн дээр энэ бол иргэнд ээлтэй ийм заалт юм байгаа юм.

Тийм учраас бол сая ажлын хэсэг дээр олонхоороо санал хураагаад энийг бол ингээд дэмжээд оруулж ирсэн санал байгаа юм аа.

Чинзориг сайдын микрофоныг өгье. Чинзориг сайд.

С.Чинзориг: Одоо ингээд мөнгөн дүн гээд гэхихлээр нэмэгдэх хувь энэ чинь тавина. Мөнгөн дүн гэж тавих болчихоод байна аа, эсвэл та нар тэр нэмэгдэх хувь эс үгүй бол мөнгөн дүнг тавьж өг өө. Тэр хувиар одоо тавихлаар өндөр хувь нэмэгдэнэ ээ гээд байгаа бол эс үгүй бол мөнгөн дүнг нь тэгэхгүй бол наадах чинь одоо ингээд шууд биччихвэл хувийг нь ч тавина, мөнгөн дүнг ч тавих болчихоод байгаа юм, нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ заалт өөрчлөгдвөл тэр мөнгөн дүн гэсэн юм байхгүй байсан цаана чинь 3, 4 заалт дахиад өөрчлөлт орох гээд байна аа. Эсвэл тэр заалтууддаа өөрчлөлтийг нь оруул. Эсвэл энийгээ хас аа л гээд байна шүү дээ.

Д.Сарангэрэл: Оруулчихаад явж байгаа шүү дээ сайд аа. Сая нөгөө 47.7-д, 47.8 гээд нэмчихсэн. Нэмээд сая ажлын хэсэг дээр ирээд оруулчихсан явж байгаа.

47.8 гээд нэмсэн байгаа Оюунцэцэг ээ. Хэдүүлээ энэ үнийн асуудал дээр ээлтэй юм хийхгүй бол энэ энэ хууль чинь ач холбогдолгүй болно шүү. Болохгүй ээ. Түрүүн нөгөө Чинбүрэн гишүүн тэр чинь бөөн асуудал үүсгэнэ шүү дээ.

2 дугаар микрофон Оюунцэцэг. Хэдүүлээ ингэе л дээ.

Тэгье ерөөсөө тэгье. Зөв сайд аа эсвэл гэж нэмээд тэгээд 9.4.6, 10.8.10 юм байна тийм ээ Оюунцэцэг дарга аа.

Оюунцэцэг дарга аа одоо дахиад 88.2.4, 9.4.6, 10.8.10 тэгж оруулаад санал хураая.

Санал хураалт.

Чинбүрэн гишүүн ээ түрүүний нөгөө ярьсан одоо нэг хувиар биш эмийн сангийн түвшинд аль болох иргэддээ хямдхан үнэтэй эм яая гэдэг дээр сайд асуудал яриад байна л даа. Чинзориг сайд энэ ерөөсөө хийгдэхгүй байгаа ажил байхгүй юу. Одоо жижиглэн дээрээ хүртэл 20 хувь нэмчхээд байгаа байхгүй юу. Ингээд хүмүүс юу энийг чинь үнийг дийлэхээ больчихоод байгаа юм. Чинзориг сайд аа энэ бол жоохон иргэдэд ээлтэй одоо тухайлбал эмийн сангууд ингэж байна шүү дээ. Яг ижил төрлийн ижил үйлчилгээтэй эмийг нэг нь 5 мянга, нэг нь 10 мянга гэнгүүтээ иргэдэд очихдоо 5 мянгын эмээ зарахгүй 10 мянгынхаа эмийг зараад байгаа байхгүй юу. Яагаад гэвэл тэн дээр биш шууд 20 хувийн ашиг нэмээд тэгээд иргэд рүү очиж байгаа эм чинь үнэтэй болоод байгаа байхгүй юу. Энийг зассан бид нар хуулийн заалтыг ажлын хэсэг дээр оруулж ирж байгаа байхгүй юу. Тэгээд юу нь үгүй ээ тэгээд 3-ны 2-оор санал хураалт. Яагаад?

Тэгээд хэн хийх юм тэрийг. 7 дахиад уншъя.

Төслийн 47 дугаар зүйлийн 47.1.1 дэх заалтын “болон орон нутгийн”, “иргэнд үзүүлэх” гэснийг, 47.1.4 дэх заалтыг тус тус хасаж, мөн зүйлийн 47.1.1 дэх заалтын “шаардлагатай” гэснийг “түгээмэл хэрэглэгддэг” гэж тус тус өөрчлөх.

Санал хураалт.

72.7 хувийн саналаар санал

дэмжигдлээ.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдэх заалтын дагуу хураалгах санал.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

81.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 13.17 дахь заалтын “нөлөөт эм,” гэсний дараа “, эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж нэмж, 13.18 дахь заалтын “биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл гэсэн төрлөөр” гэснийг “эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн хэрэглэгдэхүүн” гэж өөрчилж, мөн заалтын 13.17 дахь заалтын “эмнэлгийн хэрэгсэл,” гэснийг, 13.17, 13.19 дэх заалтын “гэсэн төрлөөр” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

3.Төслийн 2 дугаар зүйлийн “2.1 дэх заалтын” гэсний дараах ““Эмийн” гэснийг “Эм, эмнэлгийн хэрэгслийн” гэж, мөн заалтын” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

4.Төслийн 3 дугаар зүйлийн “13.6” гэсний дараа “, 13.7” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

81.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Чуулганы нэгдсэн хуралдаанд эцсийн хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Анужин танилцуулна аа.

16.48 цагт

Тав дахь асуудалдаа оръё.

Эм, эмнэлгийн хэрэгслийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийе.

Засгийн газраас шинэчилсэн найруулгыг өргөн мэдүүлэхдээ Улсын тэмдэгтийн хураамжийн тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд хөндөлт хийж нэр томъёо болоод тэмдэгтийн хураамжийн талаар нийцүүлж өөрчлөлт оруулаагүй учир ажлын хэсгээс нийцүүлэн боловсруулсан болно.

1.Холбогдуулан боловсруулсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийе.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ ээ.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Санал байхгүй байна.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.22-т заасны дагуу хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг гаргаж байна.

Санал хураалт.

Анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир.

16.50 цагт

Холбогдуулан боловсруулсан Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийе.

Энэ Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг дагаад явж байгаа хуулийн төслүүд шүү манайхан. Юмтайгаа танилц Оюунчимэг ээ, юмаа уншаа. Юу хэлэлцээд байгаа юм гээд чи асуугаад байгаа юм биш юм уу.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д

заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.22-т заасны дагуу хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг гаргаж байна.

Санал хураалт.

Эм, эмнэлгийн хэрэгслийг чинь дараад явж байгаа шүү дээ. Анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар илтгэх гишүүнийг Идэрбат гишүүнийг томилж байна аа.

16.51 цагт

Эм, эмнэлгийн шинэчилсэн найруулгын төслийг баталсантай холбогдуулан Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулъя.

Та бүхэнд тогтоолын төслийг тараасан байгаа. Тогтоолын төслийг танилцуулах уу?

Монгол Улсын Их Хурлын тогтоол

Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын ч чуулганы

хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль Шинэчилсэн найруулгыг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар Оюун-Эрдэнэд даалгасугай.

1.Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Алсын хараа-2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод заасан Монголын уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлж экспортод гарах гарцыг дэмжин брэнд болгох заалтыг үе шаттайгаар хэрэгжүүлэх.

2.Уламжлалт эмийн үйлдвэрт эм үйлдвэрлэлийн зохистой дадлын стандартыг 2029 оноос хэрэгжүүлэхтэй холбогдуулан үйлдвэрлэлд ашиглах түүхий эд, сав, баглаа боодол, тоног төхөөрөмжид татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх хөнгөлөлттэй зээл олгох асуудлыг бодлогоор дэмжих.

3.Уламжлалт эмийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах.

4.Уламжлалт эмийн дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлж экспортыг дэмжих зорилгоор шинжлэх ухаан, технологийн төсөл, судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх.

5.Биоэквивалент чанарын судалгаа хийх чадавх бүрдүүлэх зорилгоор лабораторийн тоног төхөөрөмж урвалж бодисоор хангах, хүний нөөцийг сургаж бэлтгэхэд шаардагдах санхүүжилтийг улсын төсөвт жил бүр тусгах замаар 2027 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн дотор шийдвэрлэсэн байх.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын

Их Хурал Нийгмийн бодлогын байнгын хороо Анужинд даалгасугай гэсэн тогтоолын төслийг та бүхэнд танилцууллаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Батлут гишүүн.

Батлут гишүүний микрофоныг өгье.

Д.Батлут: Энэ тогтоолын төслийн хэрэгжих хугацааг 27 он гэхэд гэж.

Д.Сарангэрэл: 2029 гэсэн байна лээ бүүр.

Д.Батлут: 2029 гэдэг нь үнэхээр бас зохистой хугацаа биш гэж харж байна. Мэдээж хүний эрүүл мэндтэй холбоотой асуудал хамгийн нэг номерын асуудал. Тэгээд эм, эмнэлгийн хэрэгсэлтэй түүнийг шинжлэн судлах лабораторийн хөрөнгө оруулалт гэдэг хамгийн нэн тэргүүний шийдэх ёстой асуудал учраас маш богино хугацаанд 2025 он гэхэд шийдэхээр ийм зохицуулалтуудыг хийж өгөх нь зүйтэй гэж харж байгаа. Ингээж байж л бид нар эхнээс нь явахгүй зүгээр шат дараалсан хэлбэрээр биш нэг том дүнгээр хөрөнгө оруулалтыг нь хийгээд шийдээд явах нь зүйтэй гэж харж байна. Тийм зарчмын.

Д.Сарангэрэл: Батлут гишүүний энэ тодруулагад хариулт өгье. Энэ яах вэ уламжлалт эмийн асуудал юм байгаа юм гишүүн ээ. Нөгөө орчин үеийн юуных биш. Энэ холбогдоод манай ЭМЯ-ныхан хариулт өгөөрэй Оюунцэцэг дарга аа.

Ажлын хэсгийн номерын микрофоныг өгье.

П.Оюунцэцэг: Яг энэ асуудалтай холбоотойгоор уламжлалтын мэргэжлийн салбар зөвлөлтэй Нийгмийн бодлогын байнгын хорооны даргын ажлын хэсэгтэй уулзалт зохион

байгуулсан байгаа. Тэд нарын хүрээнд бол одоогийн хүчин чадлаа тооцоод үзэхээр ерөнхийдөө бид нарт бас хугацаа өгөөч гэсэн санал тавьсан юм. 5 жилийн хугацаагаар бид нар бол энэ хэсгээ бүрдүүлж чадна аа гэсэн саналыг үндэслээд 2029 оноос гэсэн ийм юуг хугацааг оруулж байгаа юм.

Д.Сарангэрэл: Тэгээд 2 дугаарт Батлут гишүүнээ энэ нөгөө уламжлалт эмийн тухай байгаад байгаа юм. Тийм үйл ажиллагаа шаардлагатай юм байна лээ.

Гуравдугаарт Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 60 дугаар зүйлд 60.1-д энийг 2029 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэж яг энэ уламжлалтай холбоотой стандартыг хуулийн төслийг бас заагаад өгчихсөн юм байна лээ гишүүн ээ. Баярлалаа.

Чинзориг сайд.

С.Чинзориг: Би яах вэ энэ тогтоолын төслийн зарчмыг нь бол дэмжээд байгаа юм. Тэгээд энэ тогтоолын төслийг харахаар зөвхөн уламжлалт эм, эмийн үйлдвэрийг л дэмжсэн ийм тогтоол болчихоод байх юм. Одоо бидний баталж байгаа хууль чинь бол Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль гээд хууль батлагдсантай холбогдуулж авах арга хэмжээний тогтоол гээд байдаг. Тэгээд энэ тогтоолыг чинь харахлаар зөвхөн уламжлалт эм, эмийн үйлдвэртэй л холбоотой тогтоол болчихоод байна шүү дээ.

Миний нэг бодоод байдаг юм бол ер нь энэ стратегийн бүтээгдэхүүн эмийг төрөөс дэмжлэг үзүүлдэг байх. Татвараас хөнгөлөлт үзүүлдэг байх. Дээр нь нөгөө урт хугацааны хүү багатай зээлийн дэмжлэг үзүүлдэг байх. Энэ ханган нийлүүлэгч байгууллагад эд нарт ийм дэмжлэг ерөөсөө байхгүй байгаа шүү дээ. Тэгээд ийм нэг санаа оруулмаар байгаа юм. Тэгэхгүй бол энэ чинь зөвхөн л уламжлалтын баахан эмтэй холбоотой

юм биччихээд байна. Тэр био эквиваленттай холбоотой юмыг бол бас бид нар дэмжээд байгаа юм. Энийг хугацааг нь яагаад ингээд 2027 он гээд хойш нь шийдээд байгаа юм? Энийг бол жаахан хугацааг нь нааш нь 2026 бүр болбол бараг 2025 оноос ч юм уу хийх гээд шахах хэрэгтэй шүү дээ. 2027 он гээд тавьчихлаар наадах чинь тэгээд 2 жилийн дараа, 3 жилийн дараа тэгээд л манайхан мартаад л явчихна шүү дээ.

Тэгэхээр би тэр 2027 он онтой холбоотой юмыг жоохон урагшлуулмаар байна. Ерөнхийд нь бол тэр эм эмнэлгийн хэрэгслийг ханган нийлүүлж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад тэгээд татварын дэмжлэг үзүүлдэг байх, хүү багатай зээлийн эх үүсвэрээр бас дэмжлэг үзүүлдэг байх гэсэн ерөнхий заалт оруулмаар байгаа юм аа. Тэгэхгүй бол энэ чинь Сарангэрэл дарга аа зөвхөн уламжлалт эмтэй холбоотой л ийм тогтоол болчихоод байна шүү дээ.

Д.Сарангэрэл: Сайдын асуултад хариулъя.

Энэ тогтоолын төслийг Тамгын газар, Байнгын хорооны зөвлөх, тэгээд манай Анужин даргатай ажлын хэсгийн даргатай хамтраад энэ тогтоолын төслийг боловсруулсан юм байна лээ. Саяын яг энэ 2027 онтой холбоотой асуудал бол ЭМЯ болон ажлын хэсгээс өргөн барьсан энэ хуулийн төсөл дээр чинь яг саяын Чинзориг сайдын асуусан 5 буюу биоэквивалент чанарын судалгаа хийх чадавх бүрдүүлэх зорилгоор лабораторийн тоног төхөөрөмж урвалж бодисоор хангах хүний нөөцийг сургаж бэлтгэхэд шаардагдах санхүүжилтийг улсын төсөвт жил бүр тусгах замаар 2027 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн дотор шийдвэрлэсэн байх гэж. Энийгээ хуулийнхаа үндсэн заалт буюу 60.4-д энэ хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.1 дэх заалтыг 2027 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөнө гээд ЭМЯ-аас өөр өөрснөө хуулийн заалттай. Тэгээд энэ заалтыг бол хуулийн төсөлтэйгөө. Бид

нар ажлын хэсэг биз дээ энэ чинь. Энэ хууль дээрээ ингээд хийчихсэн байна шүү дээ та нар өөрснөө Үндсэн хууль дээрээ. Тэгээд энэ тогтоолын төсөл чинь энэ хуулийнхаа заалттай, хуульд заасан заалттайгаа уялдаад байж байгаа юм байна. ЭМЯ энэ Байнгын хороотой, ЭМЯ-тай хамтарч байсан юм бол Оюунцэцэг дарга энэндээ хариул. Өөрснөө хийчихээд тэгээд сайд нь энд гайхаад суугаад байх юм байхгүй шүү дээ хариул хариул.

Тэгээд ялангуяа яг саяын сайдын хэлсэн Оюунцэцэг дарга аа сайдын хэлсэн саналыг ялангуяа Чинзориг сайдаа ээлжилж ярья л даа. Энэ 5 дугаар заалтыг байна шүү дээ ЭМЯ-ны оруулж ирсэн санал гэж байна шүү. Ажлын хэсгийн даргад ЭМЯ оруулж ирсэн байна. Та нар тэгээд сайддаа энийгээ танилцуулдаггүй юм уу хоорондоо ярьдаггүй юм уу? Энд орж ирчхээд тал талаас зэрэг зэрэг юм яриад байх юм. Хариул 2 номерын микрофоныг өгье. Оюунцэцэг дарга аа.

П.Оюунцэцэг: Уламжлалт эмтэй холбоотой Байнгын хорооны тогтоолыг

Д.Сарангэрэл: Ажлын хэсгийн ахлагч санаачлаад Анужин дарга юу өнөөдөр сая уулзалттайгаа гараад явчихлаа л даа. Тэгээд ЭМЯ-тайгаа ажлын хэсэгтэйгээ хамтраад энэ тогтоолын төслийг хуульдаа нийцүүлээд юу боловсруулсан төслийг л би та бүхэнд танилцуулж байна шүү дээ. Тэгээд хэрвээ шаардлагагүй гэх юм бол хойшлуулъя, асуудал байхгүй. Дахиад энэ дээрээ суугаад ажиллаж болно.

Оюунчимэг гишүүн ээ, Чинзориг сайд аа. ЭМЯ Оюунцэцэг дарга хариулъя. 2 дугаар микрофон.

П.Оюунцэцэг: Эмнэлгийн мэргэжлийн салбар зөвлөлтэй бол зөвшилцөх уулзалт хийж байх үед бол энэ дээр Нийгмийн бодлогын байнгын хорооны даргаас бол уламжлалт эмийн талаар ер нь энэ Нийгмийн бодлогын байнгын хорооны тогтоол гаргаад хэрэгжүүлье гэсэн ийм саналыг гаргасан юм аа. Энэ хүрээндээ тогтоол дээр өгсөн тийм тогтоол. Ажлын хэсэг дээр нөгөө дэд ажлын хэсэгтэй бид нартай уулзалт хийсэн юм. Дэд ажлын хэсэг дээрээ бид нар уулзалтаа хийгээд мэргэжлийн салбар зөвлөлтэй зөвшилцөөд байж байхдаа ерөнхийдөө ер нь Байнгын хорооны тогтоол.

Д.Сарангэрэл: Тогтоолын төслийг хойшлууллаа. Эрүүл мэндийн сайдын саналаар. Ажлын хэсгийн дарга болон ЭМЯ энийгээ яриад нэгтгээд оруулаад ир. Тогтоолын төслийг хойшлууллаа.

Хэлэлцэх асуудал дууслаа.
Гишүүддээ баярлалаа.

14.56 цагт

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ
П.МЯДАГМАА